

RAISING AWARENESS CAMPAIGN

**ГИААН хөтөлбөрийн талаар гадаад худалдаанд
оролцогчдын мэдээлэл, мэдлэгийг
дээшлүүлэх арга хэмжээ**

**BOLORMAA Vanchindorj, Customs officer,
Risk Management Division,
Customs General Administration of Mongolia**

Гадаад худалдаанд
оролцогчдын
мэдээлэл, мэдлэгийг
дээшлүүлэх арга
хэмжээ

1

ГИААН хөтөлбөрийн тухай
ойлголт

2

Эрх зүйн зохицуулалт

3

Хэрэгжилтийн өнөөгийн байдал

4

Сурталчлан таниулах арга хэмжээ

5

Цаашид...

1. ГИААН хөтөлбөрийн тухай ойлголт



ГИААН хөтөлбөр буюу Authorized economic operator “AEO” programme:

- ДГБ-ын Зөвлөлийн чуулганы хуралдаан 2005 он:
“Дэлхийн худалдааг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх аюулгүй байдлын багц стандарт”,
- “Гааль бизнесийн түншлэл”,
- Худалдааны аюулгүй байдлыг хангах, хууль сахилтыг дэмжих, гааль бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх тухай Багц стандарт (SAFE Framework of Standards to Secure and Facilitate Global Trade (SAFE Framework))

Зорилго:

- Олон улсын худалдааны аюулгүй байдлыг хангах, худалдааг хөнгөвчлөх;
- 29 стандартыг хамтдаа хэрэгжүүлэх гааль, төрийн болон бизнесийн байгууллагын түншлэлийг буй болгох;
- Чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг тууштай дэмжих.

1. ГИААН хөтөлбөрийн тухай ойлголт



Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (Mutual Recognition Arrangement/ Agreement (MRA)):

Гаалийн байгууллага хооронд байгуулах ба харилцан хүлээн зөвшөөрч нэг гаалийн байгууллагаас нөгөөд зохих ёсоор эрх авсан ГИААН-ийн худалдааг хөнгөвчлөх үр өгөөжийг харилцан хүлээн зөвшөөрч, харилцан үүрэг, хариуцлага хүлээсэн хэлэлцээр.

Гааль-Бизнесийн түншлэл (Customs-to-Business Partnership (C-2-B)):

Аюулгүй байдлын багц стандартын 3 тулгуурын нэг, гааль ба бизнесийн түншлэлийг дэмжиж, нягт уялдаа холбоо, хамтын хариуцлагын уур амьсгалыг бүрдүүлж, хил хязгаараа хамгаалж, худалдааг дэмжих.

1. ГИААН хөтөлбөрийн тухай ойлголт



Итгэмжлэл (Authorization):

Багц стандартад тусгагдсан олон улсын суурь стандартуудыг хэрхэн дагаж мөрдөж буйг тогтоох үүднээс:

- Аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу бичиг баримт, ажлын байран дахь биет зүйлс (тоног төхөөрөмж г.м.)-ийн аюулгүй ажиллагааг хянан баталгаажуулж,
- ГИААН-ийн эрх зүйн байдлыг гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа.

ГИААН буюу АЕО:

ДГБ-аас батлан гаргасан, эсхүл түүнтэй адилтгах өөр бусад бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлын стандартыг мөрдлөг болгон ажилладаг болохыг үндэсний ГБ-аас, эсхүл ГБ-аас эрх олгосон этгээдээс батлан илэрхийлсэн, барааны олон улсын хөдөлгөөнд тодорхой үүрэг гүйцэтгэн оролцогч аль нэг тал юм.

ГИААН гэдэгт:

Бараа үйлдвэрлэгч, импортлогч, экспортлогч, зуучлагч, тээвэрлэгч, боомт, нисэх онгоцны буудал, терминалын эрхлэгч, агуулахын эрхлэгч, тээвэр зууч...

2.Эрх зүйн зохицуулалт

Олон улсын эрх зүйн зохицуулалт:

- Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц (1973 онд Япон Улсын Киото хотноо байгуулагдсан, Монгол Улс 2006 онд соёрхон баталсан);
- ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр (2017 онд хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн, Монгол Улс 2016 онд соёрхон баталсан);
- ДГБ-ын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх аюулгүй байдлын багц стандарт (Бельгийн Вант Улсын Брюссель хотноо 2005 онд ДГБ-ын Зөвлөлийн чуулганаар батласан);
- Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (Монгол Улсын Гаалийн байгууллага БНХАУ-ын Гаалийн байгууллагатай 2019 оны 04 сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан);
- Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (Монгол Улсын Гаалийн байгууллага БНСУ-ын Гаалийн байгууллагатай 2019 оны 09 сарын 30-ны өдөр гарын үсэг зурсан);
- Харилцан ойлголцлын санамж бичиг (Монгол Улсын Гаалийн байгууллага БНСУ-ын Итгэмжлэгдсэн операторын холбоотой 2023 оны 04 сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан).

Үндэсний эрх зүйн зохицуулалт:

- Гаалийн тухай хууль, 271¹.1.16, (2008);
- ГЕГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/118 дугаар тушаалаар батлагдсан “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”.

2.Эрх зүйн зохицуулалт

ШАЛГУУР

Хууль сахилтын түвшин сайн гэж тогтоогдсон байх

- Шалгуур үзүүлэлт
- Ажиллагчдын хууль сахисан байдал
 - Байгууллагын хууль сахисан байдал
 - Бүртгэлийн мэдээлэл
 - Гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэл
 - Гаалийн мэдүүлгийн алдаа
 - Татвар төлөлт
 - Удирдлага зохион байгуулалтын шаардлага
 - Гадаад өр, зээл

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны дотоод хяналт сайн байх

- Шалгуур үзүүлэлт
- Дотоод бүтэц
 - Гаалийн хэргийн мэдлэгийг бэхжүүлэх сургалт
 - Бичиг баримтын хяналт
 - Бичиг баримтын хадгалалт
 - Дотоод аудитын систем
 - Хариуцлагын тогтолцоо
 - Сайжруулах арга хэмжээ
 - Мэдээллийн систем
 - Мэдээллийн аюулгүй байдал

Санхүүгийн чадавхитай байх

- Шалгуур үзүүлэлт
- Санхүүгийн бүртгэл мэдээлэл
 - Санхүүгийн төлбөрийн чадвар
 - Ашигт ажиллагаа
 - Татвар төлөх чадвар

Гадаад худалдааны аюулгүй байдлын стандартыг чанд сахих

- Шалгуур үзүүлэлт
- Байр агуулахын аюулгүй байдал
 - Байр агуулахад нэвтрэх аюулгүй байдал
 - Ажиллагчдын аюулгүй байдал
 - Бизнесийн түншлэлийн аюулгүй байдал
 - Ачаа, барааны аюулгүй байдал
 - Чингэлгийн аюулгүй байдал
 - Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал
 - Ослын үеийн удирдлага зохион байгуулалт

Шалгуурыг хангаж, итгэмжлэл олгосон аж ахуйн нэгж (ГИААН)-д үйл ажиллагааны төрлөөс нь хамаарч хөнгөлөлт үзүүлнэ.

Үүнд:

- гаалийн бүрдүүлэлтийг дараалал харгалзахгүй хийх;
- барааг эзэмшигчийн байр, агуулах, талбайд түр хадгалах;
- бараанд хийх шалгалтаас тодорхой хувиар чөлөөлөх;
- зарим тохиолдолд барааг багцалж гаалийн нэг мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлтийг хийх;
- гаалийн хууль тогтоомжийн болон гаалийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх гаалийн улсын байцаагчийг тусгайлан томилох;
- гаалийн бүрдүүлэлтийг барааны байршлаас үл хамааран аль ч гаалийн байгууллагад хийх;
- итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн асуудлаар Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан бусад улс оронд хөнгөлөлт эдлэх.

3. Хэрэгжилтийн өнөөгийн байдал



ДГБ-ын Багц стандартыг хэрэгжүүлэх хүсэлтийг илгээсэн

Их Түмэн санаачлага ИААН Ажлын хэсэг байгуулсан

БНХАУ, БНСУ-ын ГБ-тай хамтарсан баталгаажуулалт хийсэн

ИААН-ийн хөтөлбөрийг ХХЗХ-ийн хөнгөлөлтийн талаар туршилтын төсөл хэрэгжүүлсэн

ОХУ-ын гаалийн байгууллагатай ИААН-ийн хамтын ажиллагааг эхлүүлсэн: Цахим уулзалтууд

ОХУ-ын ХГА-тай ХХЗХ байгуулах замын зураглалыг боловсруулж, Монгол, Оросын гаалийн байгууллага хооронд ИААН-ийн хөтөлбөрийн асуудлаар үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурсан

2005

2010

2016

2017

2018

2019

2020

2022

2023

ГБ-ын ИААН-ийн Ажлын хэсэг байгуулсан

ИААН туршилтын төсөл Экспортлогчдод зориулсан сургалт хийсэн

БНХАУ, БНСУ-ын гаалийн байгууллагатай ИААН-ийн асуудлаар ХХЗХ-т гарын үсэг зурсан

Монгол Улсын Гаалийн байгууллага болон БНСУ-ын Солонгосын ИААН-ийн холбоо хооронд ИААН санамж бичигт гарын үсэг зурсан

МЗХ шийдвэр, ГЕГ-ын даргын тушаал: Эрдэнэт ТӨҮГ итгэмжлэл олгох

4.Сурталчлан таниулах арга хэмжээ



Эрх зүйн эх сурвалж:

- ДХБ, ХХХ I хэсэг, Зүйл 1;
- ДГБ, ШНКК бүлэг 7, бүлэг 9, стандарт 9.4-9.7;
- Гаалийн тухай хууль, 268¹ .1 дүгээр зүйлийн 268¹ .1.11 дэх заалт.

4.Сурталчлан таниулах арга хэмжээ



1.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем



<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207130917751&type=3>

2.Гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудас


Мэдээ, мэдээлэл:

- Хоёр орны гаалийн байгууллагын хооронд байгуулсан “ГИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хамтран ажиллах талаар ярилцсан.
<https://www.customs.gov.mn/2023/04/06/>
- МУГЕГ, БНСУ-ын Итгэмжлэгдсэн операторын холбоо 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Харилцан Ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.
<https://www.customs.gov.mn/2023/05/02/>
- Эрх зүйн актын төсөлд санал авах.

4. Сурталчлан таниулах арга хэмжээ

3. Гаалийн цахим үйлчилгээний системийн мэдээлэл

- Хүсэлт гаргахад шаардлагатай мэдээлэл, танилцуулга, заавар



4. ГЕГ болон гаалийн газар, хороодод зохион байгуулагдах “Гааль бизнесийн түншлэлийн уулзалт”

- Жил бүрийн уулзалтаар мэдээлэл өгч, сонирхсон асуултад хариулах, зөвөлгөө өгөх...

4.Сурталчлан таниулах арга хэмжээ



5.“Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээ

- Асуулт хариулт, мэдээлэл солилцох
- Гарын авлага, брошюр тараах.



6.Сургалт, уулзалт, сэтгүүл

- Аж ахуйн нэгжийн төлөөлөгчтэй биечлэн уулзаж, зөвөлгөө чиглэл өгөх;
- Гааль сэтгүүлд мэдээлэл нийтлэх.



4.Сурталчлан таниулах арга хэмжээ



7.Олон нийтийн мэдээллийн цахим сүлжээ



<https://www.facebook.com/share/v/4NvpqgmUPd6PrfZ1n/?mibextid=oFDknk>



<https://www.facebook.com/share/v/6Tz3J7GwyRnSoGHP/?mibextid=oFDknk>

8.Цахим шуудан, албан бичиг

5.Цаашид...



Гааль бизнесийн түншлэлийн хүрээнд гадаад худалдаанд оролцогчидтой дараах чиглэлээр хамтарч ажиллах. Үүнд:

- 1.ГЕГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/118 дугаар тушаалаар батлагдсан “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах;
2. “Хөтөлбөр” сурталчлан таниулах арга хэмжээнд ГИААН-ийг оролцуулах;
- 3.Холбогдох төрийн байгууллагуудыг хөтөлбөрийн хэрэгжилтэд татан оролцуулах.

*Thank you for your kind
attention!*